

# **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ 8 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

## **Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

### **1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

БНХАУ-ын Эрээн хотын ардын Төлөөлөгчдийн Хурлын байнгын хорооны дарга Оюунчимэг тэргүүтэй төлөөлөгчид манай аймагт 2014 оны 8 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд ажлын айлчлал хийж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Санжжав, Эрээн хотын ардын төлөөлөгчдийн Хурлын дарга Оюунчимэг нар Сэлэнгэ аймгийн ИТХ, Эрээн хотын ардын Төлөөлөгчдийн Хурлын байнгын хорооны цаашдын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Тус санамж бичиг нь 2017 он хүртэл хүчинтэй байх юм.

УИХ-ын тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж буй "Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төсөлтэй хамтран ажилласнаар selenge.khural.mn хурлын байгууллагын албан ёсны цахим хуудастай боллоо.

Цагдаагийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд "Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус иргэний зөвлөлд орох иргэдийн материалыг хүлээн авч байна.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, Төлөөлөгчөөр сонгогдсон боловч төрийн албан тушаал давхар эрхэлж байгаа Төлөөлөгчдийн судалгааг гаргаж Авлигатай тэмцэх газар болон прокурорын байгууллагад тус тус хүргүүлээ.

### **2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Тус аймаг нь 2014 оныг "Ээлтэй орчин-Их бүтээн байгуулалт"-ын жил болгон зарлаж аймаг, сум, баг, айл хотлоороо ихийг бүтээхийг зорин хөдөлмөрлөж, бүтээсэн бүхнийхээ үр дүнг үзэн 2014 оны 8 дугаар сар 22-ны өдөр аймгийн төв Сүхбаатар суманд "Цагаан эрэг" цогцолбор, нийтийн эзэмшлийн зам талбайг сэргээн засварлаж, зүлэгжүүлэх, 2,1 км явган хүний зам барих, Оргидог булаг болон Сайханы хөтлийг тохижуулах, хүүхдийн тоглоомын болон авто машины зогсоолын талбай бий болгох ажлуудыг дуусган хүлээн авч нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Монгол улсад Ус цаг уурын байгууллага үүсч хөгжсөний 90, Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний алба байгуулагдсаны 50 жилийн ойн баяр 08-р сарын 22-ны өдөр тохиолоо. Сүүлийн жилүүдэд цаг уурчид цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх болсноор үр тариа, хүнсний ногоо, хадлан бэлчээрийн ургацыг ахиулах, ой хээрийн түймрийг унтраахад ихээхэн дэмжлэг болж, түймэр гарах, байгаль цаг уурын сөрөг нөлөөллийг багасгахад чухал нөлөө үзүүлж байна. Сүүлийн жилүүдэд шинжилгээ мэдээлэл үйлчилгээний ажлаараа улсын хэмжээнд тогтмол тэргүүн байр эзэлж байгаа. Ус цаг уурчдын ажлын үр дүнг найман настай балчираас наян настай буурлууд хүртэл бүгд өдөр бүр шалгаж, үнэлж, дүгнэж байдгаараа онцлогтой.

2014-2015 оны хичээлийн шинэ жилийн багш нарын бага хурал, семинар 2014 оны 08 дугаар сарын 26-ны өдөр эхэллээ. Тус бага хурал, семинарт манай аймгийн 35 сургуулийн захирал, сургалтын менежер, багш нар, 34 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчид нийт 500 орчим хүн хамрагдан энэ хичээлийн жилийнхээ зорилго зорилтыг тодорхойллоо.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хамтран нийт сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, газрын харилцааны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтыг зохион байгууллаа. Энэ

удаагийн сургалтаар 3 гол төслийн хэрэгжилтийн явц байдалтай танилцаж, ололт амжилт, алдаа дутагдлаа ярилцаж, цаашдын чиг хандлагаа тодорхойлсон. Холбогдох агентлагуудаас тэмдэг тэмдэглэгээний стандарт, хаягийн тоон болон цаасан зургийн зааварчилгаа, Хаягийн тухай хуулийг орон нутагт хэрхэн хэрэгжүүлж байгаатай танилцан, тус аймаг нь амжилттай хэрэгжүүлж байгааг Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын дарга А.Хүрэлшагай тодотголоо.

Халх голын ялалтын 75 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ манай аймгаас эхлэн, ойн арга хэмжээнд оролцох ОХУ-ын оюутан залуусыг хүлээн авч Алтанбулаг сум дахь худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагаатай танилцаж, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейг үзэж сонирхон, 08-р сарын 20-ны өдөр их жанжин Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүллээ.

Манай аймагт 1939 оны Халх гол, 1945 оны чөлөөлөх дайнд хоёуланд нь оролцсон нэг ахмад дайчин байдаг бөгөөд Мандал сумын харъяат 104 настай Чүлтэмийн Люмбаев гуайд Засгийн газраас 2 сая төгрөгийн тэтгэмжийг олголоо.

### **Бусад ажлын талаар:**

#### **Онцгой байдлын газар:**

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах”-уудад Гамшгаас хамгаалах болон галын түймрийн улсын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт бус хяналт, шалгалт зохион байгуулж, Сүхбаатар сумын 4, 7, 8-р баг, Баянгол сумын Гонир 3-р багуудад үйл ажиллагаа явуулдаг Улаанбаатар Төмөр Замын Сүхбаатар дахь Зүтгүүрийн депогийн нефть агуулах, “Магнай Трейд” ХХК, “Жаст-Ойл” ХХК, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Баянгол сум дахь “Улсын нөөцийн салбар” зэрэг газрын тосны бүтээгдэхүүний агуулахын нийт 3 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт, шалгалтыг хийж нийт 82 зөрчлийг илрүүлэн бусад зөрчлийг арилгуулахаар Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 3-ыг үйлдэж, байгууллагын дарга, эрхлэгч нарт өглөө.

Алтанбулаг сум Хилийн 0282 дугаар салбарын застав, Сөрт харуулын байр, Шарвагатай харуулын байр, Хилийн 0283 дугаар салбарын застав, Дүгрээ харуулын байр, Хазай харуулын байр, Хүдэр сум Хилийн 0236 дугаар салбарын застав Хүдрийн адаг харуулын байр, Уялага харуулын байр, Амж харуулын байр зэрэг нийт 10 объектыг шалгаж нийт 114 зөрчлийг илрүүлэн, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 10, албан мэдэгдэл 3-ийг үйлдлээ.

Гүйцэтгэлийн шалгалтын явцад галын аюулгүй байдлаа хангаагүй холбогдох  $\text{H}\ddot{\text{a}}\text{a}\ddot{\text{a}}\ddot{\text{b}}\ddot{\text{o}}$ ,  $\text{O}\ddot{\text{a}}\text{O}\ddot{\text{i}}\text{E}\ddot{\text{e}}\ddot{\text{e}}\text{E}\ddot{\text{I}}$   $\text{I}\ddot{\text{I}}\ddot{\text{D}}\ddot{\text{i}}\text{A}\ddot{\text{D}}\ddot{\text{E}}\ddot{\text{A}}$ ,  $\text{A}\ddot{\text{Z}}\ddot{\text{D}}\ddot{\text{Y}}\ddot{\text{I}}$ ,  $\text{A}\ddot{\text{E}}\ddot{\text{D}}\ddot{\text{A}}\ddot{\text{I}}$  хугацаатай улсын байцаагчийн өгсөн албан бичгийн хариуг ирүүлээгүй, Алтанбулаг суманд үйл ажиллагаа явуулдаг “Искра” Зочид буудлыг захиргааны хариуцлагын тухай хуулийн 25<sup>1</sup> заалтыг үндэслэн 50.000 мянган төгрөгөөр, Сүхбаатар сумын 1-р багт үйл ажиллагаа явуулж буй “Олон борлог” ХХК нь галын аюулгүй байдлаа хангаагүй холбогдох  $\text{H}\ddot{\text{a}}\text{a}\ddot{\text{a}}\ddot{\text{b}}\ddot{\text{o}}$ ,  $\text{O}\ddot{\text{a}}\text{O}\ddot{\text{i}}\text{E}\ddot{\text{e}}\ddot{\text{e}}\text{E}\ddot{\text{I}}$   $\text{I}\ddot{\text{I}}\ddot{\text{D}}\ddot{\text{i}}\text{A}\ddot{\text{D}}\ddot{\text{E}}\ddot{\text{A}}$ ,  $\text{A}\ddot{\text{Z}}\ddot{\text{D}}\ddot{\text{Y}}\ddot{\text{I}}$ ,  $\text{A}\ddot{\text{E}}\ddot{\text{D}}\ddot{\text{I}}$  ын хэрэгжилт хангалтгүй байсан тул захиргааны хариуцлагын тухай хуулийн 25<sup>1</sup> заалтыг үндэслэн 250000 мянган төгрөгөөр, барилгын зураг төслөө хянуулаагүй “Модерн” ХХК-ийг Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25<sup>1</sup> заалтыг үндэслэн 250000 мянган төгрөгийн захиргааны арга хэмжээ тус тус ногдууллаа.

Онцгой байдлын газрын даргын баталсан “Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, эрхлэж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад” Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль дүрэм стандартын хэрэгжилтийг” шалгах төлөвлөгөөт шалгалтаар шалгалтанд хамрагдсан 60 байгууллагуудад гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж урьд өгөгдсөн гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагад 139  $\text{C}^{\circ}$   $\text{D}$ -ил илэрч, гүйцэтгэлийн шалгалтын явцад 121 зөрчил дутагдал арилж 87% хувь нь биелж,

зөрчил дутагдлыг бүрэн арилгуулахаар 5 аж ахуйн нэгжид гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл хүргүүлж ажиллалаа.

**Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

“Редхилл Монголия” ХХК-ийн ОХУ-д экспортлож буй 125.13 тн чулуун нүүрсний тээвэрлэлтэнд баталгаа гаргаж, тохирлын гэрчилгээ олголоо.

2 аж ахуй нэгж, иргэнд 2 нэрийн 2 стандартаар хангах үйлчилгээ үзүүллээ.

Хүнд, массын хэмжүүр баталгаажуулахад ашиглагддаг 3 багц ажлын эталон туухайг ээлжит шалгалт, тохируулгад хамрууллаа.

Худалдаа үйлчилгээнд ашиглаж буй 9 аж ахуй нэгж, иргэний 12 жинг шалган баталгаажууллаа.

Цахилгаан хэмжлийн төрлөөр 3 фазын 1, нэг фазын 7 тоолуурыг ээлжит бус баталгаажуулалтад хамрууллаа.

Эмийн сан, сорилтын лабораторийн 4 электрон жин, 1 багц туухай, 12 шилэн хэмжээт саванд шалгалт тохируулга хийлээ.

Алтанбулаг сумын “НИК” ШТС-ын дизель түлш илүү шахалттай байж болзошгүй гэсэн дуудлагын дагуу очиж хэмжилт хийн шалгахад хэвийн байв. Мөн “МДТ” ШТС-29-ын А-92 түгээгүүр эвдэрч шингэн хэмжигчийг засварласан тул шалгуулах дуудлага өгснийг хүлээн авч цаг хугацаанд нь очиж, шалган битүүмжиллээ.

**Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

7-р сарын 30-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	8972452.9	8038431.5	89.6
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	7305580.4	6627149.8	90.7
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	46662603.40	38626608.30	82.8
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	13545122.80	10161486.80	75.0
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	4013570.70	1918347.60	47.8
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	9865809.6	5298006.00	53.7
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	2953600.00	2870298.10	97.2
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	24395561.10	24395561.10	100.0
	Боловсролын салбарт	19624289.10	19624289.10	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	2524657.10	2524657.10	100.0
	Соёл, спорт, аялал жуулчлалын байгууллага	1950308.50	1950308.50	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	124580.90	124580.90	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	171725.50	171725.50	100.0
6	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4445201.70	4445201.70	100.0
7	Засаг даргын нөөц	355320.00	290599.60	81.8

2014 оны төсвийн гүйцэтгэлийн 7 сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 89.6 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 97.2 хувь, орон нутгийн хөгжлийн

сангийн орлогын шилжүүлэг 53.7 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 75.0 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 81.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2013 оны 7-р сар	2014 оны 8-р сар
<b>Нэг.Талх, гурил, будаа</b>				
1	Гурил /1-гурил/	1 кг	1100	1100
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	900, 2000	900, 2000
3	Нарийн боов	1 кг	1900-2500	1900-2500
4	Элсэн чихэр	1 кг	1800-2000	1800-2000
5	Цагаан будаа	1 кг	2200	2200
<b>Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн</b>				
6	Хонины мах	1 кг	7200	7000
7	Үхрийн мах	1 кг	8500	8000
8	Адууны мах	1 кг	6800	6500
9	Ямааны мах	1 кг	6500	6000
10	Дотор мах цувдай	1 кг	5000	4000
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	7000	6000
<b>Гурав.Сүүн бүтээгдэхүүн</b>				
12	Сүү /задгай/	1л	700	700
13	Сүү /савласан/	1л	2500	2500
14	Тараг /задгай/	1л	800	800
15	Хорхой ааруул	1 кг	8500	8500
16	Айраг	1л	2000	2000
17	Хуурай сүү /орос/	1 кг	4000	4000
18	Өндөг	ш	350-400	350-400
<b>Дөрөв. Бүх төрлийн өөх тос</b>				
19	Ургамлын тос	1 кг	2900-3500	2900-3300
20	Өөхөн тос	1 кг	1500	1500
21	Шар тос	1 кг	8000	8000
22	Масло /задгай/	1 кг	3200	3200
<b>Тав.Хүнсний ногоо</b>				
23	Төмс	1 кг	1200	800
24	Лууван	1 кг	1500	800
25	Манжин	1 кг	1500	800
26	Байцаа	1 кг	1500	500
27	Сонгино	1 кг	2500	1500
28	Өргөст хэмх	1 кг	-	700
29	Тарвас /Монгол/	1 кг	-	
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	4000	3500
31	Алаг салат /даршилсан/	ш	1900-2500	1900-2500
<b>Зургаа.Тээвэр шатахуун</b>				





2014 оны 7-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 955 хүн байсан бол 37 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 65 ажлын байранд 57 хүнийг ажилд зуучлан, идэвхгүйн улмаас 62 иргэн хасагдаж, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 873 боллоо.

Аймгийн нийт сум, тосгодоос ирсэн жижиг дунд үйлдвэрийг шинээр байгуулах болон өргөтгөх зорилгоор бичсэн 3923.5 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 65 төслүүдийг хүлээн авч, дүн шинжилгээ хийн комиссын хурал хуралдаж, 6 сум 1 тосгоны 5 аж ахуйн нэгж, 4 иргэний 683.7 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 9 төслийг дэмжин Хаан, Хас, Төрийн банкинд хүргүүлээд байна.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг зарцуулах, хяналт тавих, үйл ажиллагааг зохион байгуулах гэрээний дагуу арилжааны банкууд болон зээлдэгч иргэнтэй хамтран ажиллах гэрээний загварыг боловсруулж банкуудын удирдлагад хүргүүлэн ажиллалаа.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээл олгох аймгийн комиссоос арилжааны банкуудтай хөнгөлөлттэй зээлийг шуурхай судлан олгох талаар уулзалт ярилцлага зохион байгууллаа.

Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийн 1-р ээлжэнд суралцсан 115 төгсөгчдөөс 81 иргэнийг ажил олгогчдийн захиалгын дагуу ажлын байранд зуучлаад байна.

#### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

“Төр-хоршооллын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь” хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвөлгөөн” Баянхонгор аймгийн Галуут суманд 2014 оны 8 сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, тус Сүхбаатар, Ерөө, Баянгол, Мандал сумдын 6 хоршоологчдийн дарга, хоршоолол хариуцсан мэргэжилтэн зэрэг 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, “Аймгийн Брэнд” бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

2014 оны 8 сарын 20-ны байдлаар аймгийн хэмжээнд 118.3 мянган га талбайд 1-р боловсруулалт, 94708 га талбайд 2-р боловсруулалт хийн нийт бэлтгэх уриншийн 90 хувийг хийгээд байна.

Үйлдвэр, хөдөө аж ахуй яам, аймгийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газар хамтран Баянзүрх дүүргийн “16-р хороолол”, 1000 нэрийн барааны дэлгүүрийн урд талбайд, “Скай”, “Дүнжингарав”, Хан-Уул дүүргийн “Хоум плаз” ХХК, 19-р хороолол, Чингэлтэй дүүргийн “Барилгчдын талбай”, 7 буудлын зам дагуу, Сүхбаатар дүүргийн “Гурван гал” зэрэг газруудад Алтанбулаг, Мандал, Орхон, Сант, Сүхбаатар, Цагааннуур, Түшиг, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Шаамар сумдын 111 ногоочид 903.5 тн төмс, 1559.2 хүнсний ногоо, 1.7 тн зөгийн бал, 95600 ширхэг даршилсан ногоог өнөөдрийн байдлаар борлуулаад байна.

Энэ намрын ургац хураалтанд үр тарианы комбайн 502, ангилан жатка 109, үтрэмийн 300 гаруй техник, төмсний комбайн 24 мөн хадлан тэжээл бэлтгэлтэнд 300 гаруй дугуйт трактор, 73-120 хадуур тармуур, 220 гаруй морин тармуур ажиллах бөгөөд техник засварын ажил 72-85 хувьтай байна.

Ургац тогтоолтын  $0\bar{0}\bar{u}\bar{a}\bar{-}\bar{e}\bar{e}\bar{n}\bar{a}\bar{i} \bar{a}\bar{z}\bar{i} \bar{a}\bar{y}\bar{u}\bar{d} \bar{a}\bar{e}\bar{i} \bar{a}\bar{e}\bar{i} \bar{o}\bar{y}\bar{i} \bar{a}\bar{y}\bar{y}\bar{i} \bar{a} \bar{i} \bar{e}\bar{e}\bar{o} 174.0$  га талбайд тариалалт хийсний  $142.0 \bar{i} \bar{y}\bar{i} \bar{.}\bar{a}\bar{a} \bar{o}\bar{a}\bar{e}\bar{a}\bar{a}\bar{e}\bar{a}$  үр тариа,  $3245.5$  га-д тэжээлийн ургамал,  $28730$  га-д тосны ургамал тариалж,  $0\bar{e}\bar{a}\bar{a}\bar{i} \bar{a}\bar{o}\bar{o}\bar{a}\bar{a}\bar{e}$  ургацыг авч үзэхэд  $130.5 \bar{i} \bar{y}\bar{i} \bar{.}\bar{a}\bar{a}$  талбайгаас  $15,1$  цн  $\bar{a}\bar{o}\bar{p} \bar{o} 194.2 \bar{i} \bar{y}\bar{i} \bar{.}\bar{o}\bar{i}$  ургац,  $\bar{o}\bar{y}\bar{a}\bar{y}\bar{y}\bar{e}\bar{e}\bar{e}\bar{i} \bar{o}\bar{d}\bar{a}\bar{i} \bar{a}\bar{e}$   $3245.5 \bar{a}\bar{a}$ ,  $18.2 \bar{o}\bar{i} \bar{a}\bar{o}\bar{p} \bar{o} 5875.5$  тн, тосны ургамал  $28315$  га  $\bar{o}\bar{o}\bar{d}\bar{a}\bar{a}\bar{a}\bar{e}$   $7.2 \bar{o}\bar{i} \bar{a}\bar{o}\bar{p} \bar{o}$   $20277 \bar{o}\bar{i}$ ,  $\bar{o}\bar{p} \bar{i} \bar{n} 2935 \bar{a}\bar{a} \bar{o}\bar{o}\bar{d}\bar{a}\bar{a}\bar{a}\bar{e}$   $144 \bar{o}\bar{i} \bar{a}\bar{o}\bar{p} \bar{o} 42.2 \bar{i} \bar{y}\bar{i} \bar{.}\bar{o}\bar{i}$ ,  $\bar{o}\bar{z}\bar{i} \bar{n}\bar{i} \bar{e}\bar{e} \bar{i} \bar{i} \bar{a}\bar{i} 2112.6 \bar{a}\bar{a}$   $\bar{o}\bar{o}\bar{d}\bar{a}\bar{a}\bar{a}\bar{e}$   $142 \bar{o}\bar{i} \bar{a}\bar{o}\bar{p} \bar{o} 30.1$  мян.тн ургац хураан авах  $\bar{o}\bar{p} \bar{e}\bar{o} \bar{a}\bar{d}\bar{u}\bar{e} \bar{a}\bar{a}\bar{e}\bar{i} \bar{a}$ .

Аймгийн нийт 17 суманд өндөр ашиг шимтэй малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажил үргэлжлэн хийдэг байна. Чех улсын олон улсын байгууллагаас Сайхан, Мандал, Баянгол сумдад Зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж, тоног төхөөрөмжийг олголоо.

“Малын тэжээл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрөл бүрийн тэжээлийн үйлдвэрлэл хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд малын тэжээлийн үйлдвэрийн цех болон өвсний хаман боогчийг түрээслүүлэх тухай ҮХАА-н яамны сайдын 2014 оны А/77 тоот тушаалын дагуу аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг Сайхан, Баянгол, Ерөө, Цагааннуур суманд зохион байгуулан ажиллаж байна.

### **Зургаа. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:**

#### **1. Газрын харилцааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 52 тоот тогтоолоор Сэлэнгэ аймгийн гзар нутгийн албан ёсны нэрийн зургийг ард иргэдэд таниулан сурталчлах, нутаг дэвсгэрийн хэмжээнд газар усны байршил тодорхойлж, албажуулах аливаа ажилд хэрэглэж хэвшүүлэх ажлын хүрээнд нэрийн зургийг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын 7 удаагийн захирамжаар өмнө нь гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа газар өмчилж авсан иргэдийн хамтран өмчлөгч хасуулах хэлцлийг үндэслэн нийт 9 иргэний газар өмчлөх эрхийг хэвээр үлдээж 24 иргэний газар өмчлөх эрхийг нээлээ.

Сүхбаатар сумаас одоо эзэмшиж буй газраа өмчилж авах хүсэлт гаргасан 12 иргэнд 1.2 га газрыг өмчлүүлэхээр Засаг даргын захирамжаар нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлэх шийдвэр гаргуулсан.

#### **2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:**

Алтанбулаг сумын 1-р багт баригдсан гүний худаг, шугам сүлжээний ажил, Мандал сумын төв болон туслах замын гэрэлтүүлгийн ажил, замын сангийн хөрөнгөөр хийсэн замын засвар тэмдэг тэмдэглэгээний ажил, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хайрган хучилттай зам, Баянгол сумын ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны барилгын засвар, цахилгаан хангамжийн шинэчлэлийн ажил, Цагааннуур сумын сургуулын засварын ажилуудыг тус тус улсын комиссоор хүлээн авлаа.

Сумын төвийн шинэчлэлтийн ажлын тендерт “Бумба Од” ХХК шалгарч, сумын төвийн шинэчлэлтийн ажлыг эхлүүлээ.

Зүүнбүрэн сумын Соёлын төвийн засварын ажилд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас хөндлөнгийн хяналт хийлээ.

Барилга, хот байгуулалтын яаманд 2015–2016 онд Ерөө сумын Бугант тосгон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул зэрэг суманд цэвэрлэх байгууламж шинээр барих, Баянгол сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх саналыг хүргүүлээ.

### **Долоо. Байгаль орчны чиглэлээр**

Аймгийн Байгаль орчны газраас “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК-ийн 2014 оны Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, 2013 оны байгаль орчны төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлттэй танилцлаа.

Мандал, Ерөө сумдын нутагт хууль бус ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох тухайн газраас албадан гаргах зорилгоор Байгаль орчны газар, Мандал сумын Засаг даргын Тамгын газар хамтран шалгалт хийлээ. Шалгалтаар угаах төхөөрөмж байрлуулсан, газрын хэвлийг ухаж өмнөх байдлыг алдагдуулсан байсан. Иймд угаах төхөөрөмжүүдийг лацдан, газрын хэвлийд учруулсан хохирлыг “Сайхан Ариун Дэлхий” ХХК-иар гаргуулж, тухайн газраас нэн даруй гарах шаардлага тавьж ажиллалаа.

### **Долоо.Сум орон нутгийн талаар:**

#### **1.Баянгол сум:**

БНХАУ-ын Эрээн хотын ардын Их хурлын ын дарга тэргүүтэй албаны хүмүүстэй туршлага солилцох уулзалт ярилцлагыг 2014 оны 08 сарын 13-ны өдөр зохион байгууллаа.



2014-2015 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд сумын хэмжээнд 72 тн өвс, тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх ёстойгоос 2013 оны үлдэгдэл өвснөөс гадна 28 тн өвс, тэжээл бүрдүүлэх шаардлагатай байгаа тооцоог гаргаж аймгийн Онцгой байдлын газар хүргүүлээ.

Баянгол сумын Уяачдын баяр-2014 арга хэмжээг 2014 оны 8 дугаар сарын 16-ны өдөр сумын хэмжээнд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд нийт 34 адуучин оролцож Баян багийн адуучин Б.Бямбасүрэн 1-р байр, Хараа багийн адуучин С.Гантулга 2-р байр, Баян багийн адуучин н.Шинэбаяр 3-р байранд шалгарлаа.

Сумын Засаг даргын 2014 оны А/168 тоот Ажлын хэсэг байгуулах тухай захирамж гарч орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Гонир, Баян багийн гэр хорооллын гэрэлтүүлэг, зам засварын ажлыг гүйцэтгүүлэн хүлээж авлаа.

## **2.Жавхлант сум:**

Тайлант сард “Сэлэнгэ–Моностой” ХХК–ийн урилгаар БНСУ-ын ПАЖУ эмнэлгийн нарийн мэргэжлийн 25 хүний бүрэлдэхүүнтэй эмч нарын баг тус суманд ажиллаж зүрх судас, дотор, ЭХО, мэс засал, шүд, нөхөн сэргээх гэсэн чиглэлээр давхардсан тоогоор 1420 хүнд үнэ төлбөргүй эрүүл мэндийн үзлэгийг хийлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Бумбат, Моностой багуудын өдөрлөгийг 2014 оны 8 сарын 6, 7-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 2 багийн 350 иргэн хамрагдлаа.

Тус сумын Засаг даргын 2014 оны А/68 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан 2014 оны сумын ургац хураалтын урьдчилсан балансыг гаргалаа. Үүнд: Улаан буудай 4316 га талбайд тариалж 6140 тн ургац, төмс, хүнсний ногоо 135 га тариалж 1240 тн ургац, тосны ургамал 1700 га талбайд тариалж 1900 тн ургац тус тус хураан авах урьдчилсан дүн гарлаа.

Булаг, шандны эхийг хашиж хамгаалах ажлын хүрээнд Бумбат 1-р багийн нутагт дэвсгэрт орших “Залан Хайдав”-ын рашаан, Моностой 2-р багийн нутаг дэвсгэрт орших “Сөрт”-ийн булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг иргэдийн оролцоотойгоор хамтран хийж гүйцэтгэлээ.

## **3.Ерөө сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 2014 оны 8 сарын 20-ны өдөр Бугант тосгоны нийт 11 хүнсний дэлгүүр мухлагт хяналт шалгалт хийн хугацаа дууссан, шаардлага хангахгүй 3 нэр төрлийн 74 ширхэг бараа, бүтээгдэхүүнийг устгалд орууллаа

Тайлант сард тус сумын “Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3-н талт хамтын гэрээ хэлэцэр, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн” уулзалт боллоо. Уг уулзалтанд сумын төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийн ажил олгогч болон ажилтнууд, салбар хороодын гишүүд оролцлоо.

Тус сумын Засаг даргын орлогчийн “Хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу Засаг даргын Тамгын газраас Могойн гол, Цамхагын гол, Өлөнтийн гол, Харганатын голын чиглэлд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, ахмадын өргөө хамтран “Хаш чулуу” сэргээн засах үйлчилгээнд 6 ахмад настан, 2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг эмчлүүлэх ажлыг зохион байгууллаа.

## **4.Зүүнбүрэн сум:**

2014 оны 08 дугаар сарын 21-ний өдөр тус сумын Мангирт 3-р багийн Иргэдийн Нийтийн Хурлыг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны улсын байцаагч, Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн, Улсын бүртгэгч нар ажиллан ард иргэдэд мэдээлэл өгч, төрийн үйлчилгээг үзүүлж, нийт 80 гаруй иргэд хамрагдлаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас оюутан залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Сумын залуус” сэдэвт аяныг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, авлигын эсрэг “Би өгөхгүй, авахгүй” аяныг зохион байгуулан авлигад өртөх эрсдэл бүхий төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдаар амлалтын гарын үсэг зурууллаа.

Ардын элч-Залуу үйл ажиллагааны хүрээнд тус сумын Засаг даргын Тамгын газраас Оюутан залуусын сайн нийгмийн идэвхийг нэмэгдүүлж, сумын Улаан загалмайн хороотой хамтран сумын төвөөс алслагдсан Мангирт 3-р багийн малчдад хувцас тараах ажлыг зохион байгууллаа.

#### **5.Мандал сум:**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд хүнсний дэлгүүрийн өргөтгөлийн чиглэлээр 1 төсөлд 5 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, шинээр байнгын 3 ажлын байр бий боллоо.

Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрт хамрагдан ойн мэргэжлийн ажилтан, барилгын өргөн мэргэжлээр суралцаж төгссөн 25 иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа.

Эзэнтэй Монгол хөтөлбөрийн хүрээнд “Ногоон Мандал” төсөлд хамрагдаж буй 20 иргэн наадмын талбай, цэцэрлэгт хүрээлэнгүүдэд 1100 м<sup>2</sup> талбайд зүлэг, 1200 м<sup>2</sup> талбайтай хүлэмжинд 3 кг 4 төрлийн хилэн цэцэг тарьж, 12000 м<sup>2</sup> талбайн хог хаягдлыг цэвэрлэж ажиллалаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн “Сумын залуус” төсөлд хамрагдаж буй их, дээд сургуульд өдрийн ангиар суралцаж байгаа 20 оюутан 5 баг болон бүлгийн зохион байгуулалтаар ажиллаж, сумын ажилгүй иргэдийн судалгааг гаргаж, Хүүхдийн ордон, Нэгдсэн эмнэлгийн хамт олонтой хамтран боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр сургалт зохион байгууллаа.

#### **6.Сант сум:**

Тус сумын Засаг даргын 2014 оны А/57 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг төмс хүнсний ногоо, үр тарианы ургац тогтоох ажлыг зохион байгууллаа.Үүнд: үр тарианы 3384 га талбайн ургацыг тогтоож сумын дүнгээр улаан буудай га-аас 16.7 цн, нийт 3267 га талбайгаас 5574.4 тн ургац, овъёос, арвайг 20 цн-ээр тогтоож 62 га талбайгаас 131 тн ургац, тэжээлийн ургамал 15 цн-ээр тогтоож 5 га талбайгаас 7.5 тн ургац, рапс 9 цн-ээр тогтоож 393 га-аас 379.8 тн ургац, /93 га талбайн ургац алдсан/, төмс 156 цн-ээр тогтоож 190 га талбайгаас 2966 тн ургац, хүнсний ногоо 157 цн-ээр тогтоож 180.3 га-аас талбайгаас 2830.9 тн ургац тус тус тогтоосон байна. Мөн 5 аж ахуйн нэгж, 5 иргэн нийт 3199.76 га талбайд уринш хийсэн байна.

Улаанбаатар хотын Дүнжингарав худалдааны төвд 2014 оны 8 сарын 20–оос эхлэн зохион байгуулагдаж буй төмс, хүнсний ногоо борлуулах худалдаанд тус сумын нийт 6 иргэн оролцож байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2014 онд Сант суманд хийгдэх ажлуудын тендер шалгаруулалтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна.

Тайлант сард тус сумын Засаг даргын Тамгын газраас Хушаат, Ивэн багийн “Малчдын өдөрлөг”-ийг нэгтгэн Ивэн багийн Тэлдийн аманд зохион байгуулж 160 гаруй малчид, мал бүхий иргэд хамрагдан, 32 бөхийн барилдаан, 6 насны морьдын уралдаан, шилмэл хээлтүүлэгч малын үзэсгэлэн, караоке тэмцээн, эрүүл мэндийн үзлэг, залуу гэр бүлийн дунд хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгууллаа.

#### **7.Сайхан сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Шинэчилж шийдье-Ухаалаг төрийг сумаас” сэдэвт нээлттэй өдөрлөгийг 2014 оны 08-р сарын 08-ны өдөр “Сумын залуус” төсөлд хамрагдсан оюутан залуустай хамтран амжилттай зохион байгууллаа.

Сайхан сумын Засаг даргын Тамгын газраас 2014 оны 08-р сарын 15-ны өдөр Номгон тосгоны Захирагчийн албатай хамтран Номгон 3-р багийн нутаг Ширээ булаг гэх газар “Хүлээж биш хүрч үйлчилье” нээлттэй өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж, тус газар зусаж буй 40 гаруй малчин өрхөд төрийн үйлчилгээг үзүүлж, гарын авлага, материалаар хангаж ажиллалаа.

Номгон тосгоны захирагчийн алба, тус сумын соёлын төв хамтран 2014 оны 8-р сарын 2, 3-нд Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн үе үеийн төгсөгчдийн дунд зохион байгуулагдсан урлаг спортын арга хэмжээ хамтран зохион байгуулж, тус үйл ажиллагаанд 250 гаруй иргэд хамрагдлаа.

#### **8.Сүхбаатар сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Адра Монгол олон улсын байгууллагаас чадавхижуулж буй Сүхбаатар сумын “Баянхан” бүл хамтран “Шинэ ургацын ногоог даршилж нөөцлөх технологи” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж буй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулсан сумын “Залуус төсөл”-д нийт 44 оюутныг хамруулан “Соёлын өвийг хамгаалах”, “Авилга би авахгүй, өгөхгүй”, “Англи хэл”, “Спирт үү, спорт уу”, “Эрүүл мэнд, хариу нэхээгүй тус” “Сумын аялал”, “Ардын элч залуу” зэрэг сэвүүдээр иргэдэд сургалт, зөвлөгөө мэдээллийг өглөө.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс зохион байгуулж буй Худалдагч касс няравын сургалтанд Сүхбаатар сумаас “Мэргэн төөгий”, “Залуу Сэлэнгэ” ХХК, “Цахим ертөнц” ХХК, “Сэлэнгэ менежмент” ХХК, “Таван хан” ХХК, “Тахилгат суварга” ББН, “Шинэ-бадрах” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагаас ажил олгогчийн захиалгаар 20 иргэн, хувиараа 4 иргэн суралцаж төгсөөд байна.

#### **9.Хушаат сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас гахайн аж ахуй эрхэлж буй 48 өрхийн 783 толгой гахайд “Гахайн сонгомол мялзан өвчний урьдчилан сэргийлэх эмнэл зүй”-н үзлэг тандалтыг хийж, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний талаар заавар зөвлөмжийг өглөө.

2014 оны мод бэлтгэлийн ажил 8-р сард идэвхтэй хийгдэж ойн цэвэрлэгээний огтлолоор 157 м<sup>3</sup> мод бэлтгэхээр гэрээ хийн, мод бэлтгэлийн ажил хийгдэж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлд 38 байгууллага, аж ахуйн нэгжийн 119496.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 132 хүний 17882.2 мянган төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн даатгалд 164 хүний 2031.7 мянган төгрөгийн хураамжийг оруулаад байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Малчидтай хадлангийн талбайн гэрээ байгуулж, 70 малчин өрхөөс 173600 төгрөгийг орон нутгийн орлого ба багийн нэмэгдэл нэмэгдэл санхүүжилтийн дансанд төвлөрүүллээ.

#### **10.Хүдэр сум:**

2014 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх мал тарилгын хашааны гүйцэтгэл 100 хувь, гудамжны гэрэлтүүлэгийн ажил хийгдээд 50%-ийн явцтай байна одоогоор 12 сая төгрөгийн санхүүжилт олголоо.

“Морин хуур уртын дуу” үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд тус сумын соёлын төв сарын аян зохион байгуулж, шавь сургалт хичээллүүлсэн.

Дархан-Уул аймгийн Төмөрлөгийн үйлдвэрт баяжуулалтын оператораар суралцсан 20 иргэнийг шалгаруулалтанд оруулж 11 иргэнийг шинэ ажлын байранд зуучиллаа.

“Ажилтай орлоготой Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Сумын залуус” төсөлд хамрагдахаар хүсэлтээ ирүүлсэн 8-н оюутаны “Дөрвөн бэрх” 1, 2-р багийн үйл ажиллагааг зохион байгуулан амжилттай дууслаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас мод бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 7 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийх ажлыг зохион байгууллаа.

#### **11.Орхонтуул сум:**

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан “Ахмад настанд тусламж хөнгөлөлт үзүүлэх тухай” журмын хэрэгжилтийг хангаж сумын байгалийн үзэсгэлэнт газарт байрлах “Ар булаг” амралтын газарт Эрүүл мэндийн төвтэй хамтран 20 ахмад настанг эмгүй эмчилгээ, сувилгаанд хамруулж уг ажилд Засаг даргын нөөц хөрөнгөөс 800.0 мянган төгрөгийг зарцууллаа.

Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж буй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулсан сумын “Залуус төсөл”-д 8 оюутан хамрагдаж 2 баг болон 4 ажлын хүрээнд ажил зохион байгуулан ажлын тайлан мэдээгээ хөдөлмөрийн хэлтэст хүргүүлээ.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан “Бүтээмж” багийн ахлагч Б.Эрдэнэтогтох 2014 оны 08-р сарын 04-ний өдөр Төмсний тариалан эрхлэх ерөнхий ойлголт, Хүнсний ногоо тариалахын ач холбогдол, талбайг сонгох, ээлжлэн тариалалтын ач холбогдол, төрөл бүрийн байцаа тариалах агротехник, мөн төрөл бүрийн үндэс үрт ногоо тариалах талаар, гишүүн С.Жамсран малчин мал бүхий иргэдэд малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг дээшлүүлэх, эрүүлжүүлэх чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зөвлөмж боловсруулан иргэдэд сургалт зохион байгууллаа.

#### **12.Орхон сум:**

Тайлант сард Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тус сумын Засаг даргын Тамгын газрын зочид буудлын гадна тохижилт болон хашаажуулах ажлыг олон нийтийн оролцоотой бараа ажил үйлчилгээ худалдан авах журмын дагуу сонгон шалгаруулж, “Цэвэр орчин” бүлэгтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэлийн ажлын явц 80 хувьтай байна. Тус ажлын нийт төсөвт өртөг 4800000 төгрөгөөр хийгдэж байна.

2014 оны ургацын урьдчилсан балансыг тарималын төрөл тус бүрээр тарьсан талбайтайгаа уялдуулан аж ахуйн нэгж, иргэн тус бүрээр гаргалаа. Үүнд: хүргүүлсэн төдийгүй сумын хэмжээнд нийт 12471 га талбайд үр тариа тариалснаас 9753 га-д улаан буудай, га-гийн ургац 13,3 цн, тосны ургамал 2543 га-гаас 5 цн, төмс 300га-гаас 15цн, хүнсний ногоо 111га-гаас 15,6 цн-ээр тус тус тогтоогдлоо.

Монгол Улсын засгийн газрын 2013 оны 394 тоот тогтоол “Хонины ноос, тэмээний ноос үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу хонины ноосоо үндэсний үйлдвэрт тушаасан 3 аж ахуйн нэгж, 135 иргэний 40.9 тонн ноосны материалыг хүлээн авч бүртгэн аймгийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газарт хүлээлгэн өглөө.

Тайлант сард тус сумын нутагт зөвшөөрөлгүй бэлчээр ашигласан Баруунбүрэн сумын харъяат 1 иргэн, Орхон сумын 4 иргэнийг Газрын тухай хууль тогтоомжинд заасны дагуу тус бүр 192000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан төдийгүй аймгийн онцгой комиссын 08 тоот албан даалгаврын хүрээнд сумын Засаг даргын А/128 тоот захирамж гарч, тус албан даалгаврын хүрээнд гол дагуу зусаж байгаа айл өрх, төмс хүнсний ногоо тариалсан иргэд аж ахуй нэгжийн судалгаа гаргаж, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх 11 заалт зорилт бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа.

#### **13.Цагааннуур сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Шүрэнгийн голын малчдын өдөрлөгийг 2014 оны 8 сарын 22-нд, Тийрэг багийн малчдын өдөрлөгийг 8 дугаар сарын 24-ны өдөр тус тус зохион байгууллаа.

Өдөрлөгөөр Сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга нар малчдад мэдээлэл хийж, сум дундын ойн ангийн хамт олон ойн ангиас зохион байгуулсан үйл ажиллагааны талаар, Гацуурт ХХК-ын ажилчид өөрийн төслийн талаар танилцуулан малчдын санал хүсэлтийг хүлээж авлаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас сумын байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын уулзалтыг 2014 оны 8 сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Ì àë÷äûí õ° ä° èì ° ð ýðëýëòèéãäýì æë õ° ò° ëá° ðò òàì ðàããñàì тус сумын 10 ì àë÷ëí ä Олаанбаатар õì õùí “Èòãýë á¿òýýì æ” сургалтын төвтэй хамтран “Сүү, цагаан идээ”-í èé 14 õì í î æëíí ñóðãàèò ÿâуулæýðëýýä äàéí à.

#### **14.Шаамар сум:**

UBS телевиз Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн салбарт цоо шинэ сэтгэлгээний манлайлал бий болгох шинэ үеийн залуусыг тодруулах “Улс төрд шинэ манлайлагч” зорилтот телевизийн төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Төслийг EBI хүрээлэн, Liberal House бодлогын судалгааны хүрээлэнтэй хамтран орон даяар зохион байгуулж, тус суманд 2014 оны 08 сарын 10-ны өдөр ажиллалаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас төмс, хүнсний ногооны борлуулалтын ажилт хяналт тавьж, Улаанбаатар хотод борлуулах шинэ ургацын үзэсгэлэн худалдаанд тус сумын 33 иргэн 5 дүүрэгт талбай авч борлуулалтаа хийж байна.

2014 оны сумын ургац тогтоох ажлын хэсгийг байгуулж, ажиллан баг тус бүрээр гаргаж, аймгийн Мэргэжлийн хяналтын газраас өгсөн чиглэлийн дагуу төвлөрсөн хогийн цэгийн ойролцоох, төмс хүнсний ногоо тариалдаг, иргэдийн талбайгаас дээж авч хүргүүллээ.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР